



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 13 өдөр

Дугаар 9/89

Хэрлэн сум

Гал түймэрт өртсөн айл өрхүүдэд
буцалтгүй тусламж үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, аймгийн Онцгой комиссын №02 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1.Өмнөдэлгэр сумын Гурванбаян тосгонд гарсан объектын гал түймэрт өртсөн өрхүүдэд 10,000,000 (арван сая) төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсүгэй.
- 2.Шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.
- 3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.
- 4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023
оны 02 дугаар сарын 13-ны
дугаар захирамжийн хавсралт

Шаардагдах зардлын тооцоо

№	Шаардагдах зүйлс	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Нийт дүн
1	Өрхөд мөнгөн дэмжлэг үзүүлэх зардал	ш	Өрх 1- 1 сая Өрх 2- 1 сая Өрх 3- 1 сая Өрх 4- 0,5 сая Өрх 5- 1,5 сая	5	5,000,000
2	Гэр олгох зардал	ш	5,000,000	1	5,000,000
			Нийт		10,000,000